



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/267

Мандалговь

Архи согтууруулах ундаа худалдан борлуулах,
түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй Сайнцагаан сумын "Тогтох мандал" ХХК-ны хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, "Силвер кров" ХХК-ны зоогийн газарт архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

2. "Тогтох мандал", "Силвер кров" ХХК-ний худалдаа үйлчилгээний газруудын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08⁰⁰ -24⁰⁰ цаг хүртэл хугацаагаар тус тус баталсугай.

3. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210912